



286

БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1992 оны 9 сарын 14

№ 220
133 93 А/21 Захиулар

Улаанбаатар хот

Хотын малын захын тухай

Хотын малын захын байршил, зохион байгуулалтыг сайжруулж үйл ажиллагааг нь өргөжүүлэх асуушлыг хэлэлцээд Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. "Түшиг" компани нь хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 183 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, хотын малын захын үйлчилгээг тогтмолжуулж өргөжүүлэх талаар тодорхой ажил зохиогоогүй, өөрийн туслах жж ахуйн хэмжээнд ажиллуулж, үүргээ хангалтгүй биелүүлсэн тул хотын малын захыг тус компанийн харьяаллаас гаргаж 10 дугаар сарын I-нээс эхлэн бие даасан аж ахуйн нэгж байхаар Малын захын түр захиргаа байгуулж ажиллуулахыг хотын Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийг удирдах газар /н.Мижиддорж/-т цаалгасугай.

2. Октябрь дүүргийн ОСГ-ны 2 дугаар хорооны цэвсгэр нутагт малын зах ажиллуулах зориулалтаар 0,6 га газрыг малын захын түр захиргаанд эзэмшүүлэхийг Хот байгуулалт, төлөвлөлтийн газар /н.Болд/-т зөвшөөрсүгэй.

3. Сонсголон дахь хуучин малын захын хашаа байрыг 4,5 га эцэлбэр газрын хамт хотын хүнсний захад 10 дугаар сарын I-ний дотор эргүүлж шилжүүлэхийг хотын ХААХҮУ газар /н.Мижиддорж/-т, тэдгээрийг зориулалтын дагуу үргэлжлүүлж ашиглахыг хотын Хүнсний зах /н.Ширчин/-д тус тус цаалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Л.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАЙХАН